



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/118

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хүүхдийн 1, 2, 3, 4, 5 дугаар цэцэрлэгт нийлүүлэгдэж байгаа гадна болон интерактив тоглоомыг хүлээж авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Нямдаваа (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Гишүүдэд:

О.Мөнх-Отгон (1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Наянжин (2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Г.Ганчимэг (3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

П.Осорхүү (4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч)

Б.Байгальмаа (5 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

2. Холбогдох журмын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулж, танилцуулахыг ажлын хэсэг (Н.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100235